

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Т.Амармэнд
Утас: 70453721, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022. 02. 25 № УВН-2022/08/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

САГИЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
С.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200200425

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	96,392,460.10	76,102,648.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	8,693,892.00	18,480.00
335	Бусад авлага	8,693,892.00	18,480.00
3351	Байгууллагаас авах авлага	2,293,892.00	18,480.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,400,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	87,698,568.10	76,084,168.10
354	Хангамжийн материал	87,698,568.10	63,634,168.10
35410	Бичиг хэргийн материал	414,000.00	809,600.00
35420	Аж ахуйн материал	32,324,068.10	41,079,068.10
35430	Сэлбэг хэрэгсэл	2,960,500.00	4,945,500.00
35470	Бусад хангамжийн материал	52,000,000.00	16,800,000.00
35600	Мал амьтад	00.00	12,450,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	644,292,937.11	729,349,175.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	644,292,937.11	729,349,175.00
392	Биет хөрөнгө	620,688,737.11	705,744,975.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	617,573,723.00	607,523,252.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-193,715,010.10	-162,750,803.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	143,810,000.00	241,310,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-70,366,319.47	-95,986,319.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,175,294.00	134,885,814.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,807,307.08	-66,111,301.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,342,216.61	67,129,627.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,549,352.07	-22,023,502.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,974,579.00	5,161,418.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,749,086.78	-3,393,209.42
393	Биет бус хөрөнгө	23,604,200.00	23,604,200.00
39301	Программ хангамж	1,555,000.00	1,555,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,555,000.00	-1,555,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	23,604,200.00	23,604,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	740,685,397.21	805,451,823.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	996,388.00	3,046,694.73
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	996,388.00	3,046,694.73
413	Өглөг	996,388.00	3,046,694.73
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	20,000.00
4136	Бусад өглөг	996,388.00	3,026,694.73
41361	Байгууллагад төлөх өглөг	247,388.00	3,026,694.73
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	749,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	739,689,009.21	802,405,128.37
51	Засгийн газрын хувь оролцоо	739,689,009.21	802,405,128.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	263,465,465.00	263,465,465.00
51101	Өмч: - төрийн	263,465,465.00	263,465,465.00
512	Хуримтлагдсан үр дүн	336,534,516.99	399,317,307.10
51210	Өмнөх үеийн үр дүн	336,534,516.99	336,601,187.94
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	62,716,119.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,689,027.22	139,622,356.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	740,685,397.21	805,451,823.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	758,894,963.10	695,523,198.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	205,197,778.10	192,043,233.00
120	Нийтлэг татварын бус орлого	205,197,778.10	192,043,233.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	205,197,778.10	192,043,233.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	205,197,778.10	192,043,233.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	553,697,185.00	503,479,965.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,151,285.00	16,809,665.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	710,000.00	11,970,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,626,285.00	750,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	815,000.00	4,089,665.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	505,545,900.00	486,670,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	505,545,900.00	486,670,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	592,140,199.95	632,807,078.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,851,199.95	632,807,078.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	532,966,741.20	578,905,817.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,969,985.00	268,133,818.79
210101	Үндсэн цалин	235,741,085.00	220,686,901.79
210105	Гэрээт ажлын хөлс	43,228,900.00	47,446,917.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,034,414.25	33,483,494.07
210201	Тэтгэврийн даатгал	23,236,858.64	24,031,064.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,700,117.59	2,371,146.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,166,775.46	2,140,147.80
210204	Ажилгүйдлийн даатгал	554,833.59	448,575.37
210205	Эрүүл мэндийн даатгал	5,375,828.97	4,492,559.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,803,530.00	64,256,880.61
210301	Гэрэл, цахилгаан	6,341,238.00	9,920,119.88
210302	Түлш, халаалт	45,362,292.00	54,336,760.73
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,284,486.00	23,935,519.00
210401	Бичиг хэрэг	3,921,030.00	3,076,900.00
210402	Тээвэр, шатахуун	17,763,276.00	14,292,109.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,720,880.00	1,376,910.00
210404	Ном, хэвлэл	182,800.00	190,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	435,500.00	2,871,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	261,000.00	2,127,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,138,200.00	635,500.00
210604	Урсгал засвар	2,138,200.00	635,500.00
2107	Томилолт, зочны зардал	5,694,000.00	4,100,000.00
210702	Дотоод албан томилолт	5,694,000.00	4,100,000.00

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,648,665.00	1,554,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,000.00	272,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	113,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,565.00	78,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	214,000.00	286,000.00
210807	Газрын төлбөр	560,000.00	472,594.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,393,460.95	182,806,151.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,733,539.00	94,914,156.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,016,300.00	2,342,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,643,621.95	85,549,495.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,884,458.75	53,901,261.26
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,160,000.00	17,973,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	11,653,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	5,040,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,160,000.00	1,280,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,724,458.75	35,927,861.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,724,458.75	35,927,861.26
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,289,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	39,289,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	39,289,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	166,754,763.15	62,716,119.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,591,082.14	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,591,082.14	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,591,082.14	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	165,163,681.01	62,716,119.16

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	553,697,185.00	503,479,965.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	553,697,185.00	503,479,965.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,151,285.00	16,809,665.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	710,000.00	11,970,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,626,285.00	750,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	815,000.00	4,089,665.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	505,545,900.00	486,670,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	505,545,900.00	486,670,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	498,751,105.00	503,479,965.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	498,751,105.00	503,479,965.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	478,406,646.25	449,556,703.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,924,640.00	267,494,714.00
210101	Үндсэн цалин	232,541,986.00	220,647,797.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,382,654.00	46,846,917.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,343,974.25	33,805,986.86
210201	Тэтгэврийн даатгал	23,702,829.34	24,049,544.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,711,288.82	2,675,159.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,169,131.46	2,140,147.80
210204	Ажилгүйдлийн даатгал	542,257.36	448,575.78
210205	Эрүүл мэндийн даатгал	5,218,467.27	4,492,559.34
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,787,992.00	61,566,057.88
210301	Гэрэл, цахилгаан	6,325,700.00	9,935,657.88
210302	Түлш, халаалт	45,362,292.00	51,630,400.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,504,446.00	20,480,069.00
210401	Бичиг хэрэг	3,124,130.00	3,135,900.00
210402	Тээвэр, шатахуун	12,248,636.00	12,205,659.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,731,880.00	1,376,910.00
210404	Ном, хэвлэл	206,800.00	190,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	833,000.00	2,871,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	360,000.00	699,600.00
2105	Нормативт зардал	00.00	830,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	830,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,819,000.00	2,834,200.00
210604	Урсгал засвар	4,819,000.00	2,834,200.00
2107	Томилолт, зочны зардал	4,945,000.00	4,849,000.00

210702	Дотоод албан томилолт	4,945,000.00	4,849,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,345,165.00	1,212,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	981,500.00	250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	113,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,565.00	78,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	479,000.00	286,000.00
210807	Газрын төлбөр	560,000.00	152,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,736,429.00	56,484,556.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,224,129.00	54,434,556.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,512,300.00	2,050,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,344,458.75	53,923,261.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,620,000.00	17,995,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	11,653,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	5,040,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,620,000.00	1,302,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,724,458.75	35,927,861.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,724,458.75	35,927,861.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	54,946,080.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	54,946,080.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,946,080.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,946,080.00	00.00
223001	Бусад хөрөнгө	54,946,080.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-54,946,080.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	263,465,465.00	139,809,907.51	171,249,955.69	574,525,328.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	120,880.29	120,880.29
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,465,465.00	139,809,907.51	171,370,835.98	574,646,208.49
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	165,163,681.01	165,163,681.01
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,465,465.00	139,689,027.22	336,534,516.99	739,689,009.21
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	263,465,465.00	139,689,027.22	336,534,516.99	739,689,009.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	66,670.95	66,670.95
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,465,465.00	139,689,027.22	336,601,187.94	739,755,680.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-66,670.95	00.00	-66,670.95
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	62,716,119.16	62,716,119.16
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,465,465.00	139,622,356.27	399,317,307.10	802,405,128.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	ЗӨРҮҮ	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	482,070,300.00	454,547,738.74	27,522,561.26	94.3%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	482,070,300.00	454,547,738.74	27,522,561.26	94.3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,876,900.00	436,552,338.74	27,324,561.26	94.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,498,700.00	267,494,714.00	6,003,986.00	97.8%
210101	Үндсэн цалин	226,291,200.00	220,647,797.00	5,643,403.00	97.5%
210105	Гэрээт ажлын хөлс	47,207,500.00	46,846,917.00	360,583.00	99.2%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,921,000.00	33,805,986.86	3,115,013.14	91.6%
210201	Тэтгэврийн даатгал	25,982,300.00	24,049,544.20	1,932,755.80	92.6%
210202	Тэтгэмжийн даатгал	2,733,600.00	2,675,159.74	58,440.26	97.9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,188,100.00	2,140,147.80	47,952.20	97.8%
210204	Ажилгүйдлийн даатгал	547,000.00	448,575.78	98,424.22	82.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,470,000.00	4,492,559.34	977,440.66	82.1%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,750,000.00	61,566,057.88	1,183,942.12	98.1%
210301	Гэрэл, цахилгаан	10,825,700.00	9,935,657.88	890,042.12	91.8%
210302	Түлш, халаалт	51,724,300.00	51,630,400.00	93,900.00	99.8%
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	00.00	200,000.00	0.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	19,578,400.00	17,955,110.00	1,623,290.00	91.7%
210401	Бичиг хэрэг	3,136,900.00	3,135,900.00	1,000.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	9,712,800.00	9,680,700.00	32,100.00	99.7%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,944,400.00	1,376,910.00	567,490.00	70.8%
210404	Ном, хэвлэл	250,000.00	190,800.00	59,200.00	76.3%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,833,000.00	2,871,200.00	961,800.00	74.9%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	701,300.00	699,600.00	1,700.00	99.8%
2105	Нормативт зардал	833,000.00	830,000.00	3,000.00	99.6%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	833,000.00	830,000.00	3,000.00	99.6%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,635,000.00	2,834,200.00	1,800,800.00	61.1%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,800,000.00	00.00	1,800,000.00	0.0%
210604	Урсгал засвар	2,835,000.00	2,834,200.00	800.00	100.0%
2107	Томилолт, зочны зардал	5,733,100.00	4,849,000.00	884,100.00	84.6%
210702	Дотоод албан томилолт	5,733,100.00	4,849,000.00	884,100.00	84.6%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,679,900.00	1,212,120.00	2,467,780.00	32.9%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	250,000.00	0.00	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	288,000.00	115,200.00	71.4%
210803	Даатгалын үйлчилгээ	210,000.00	113,850.00	96,150.00	54.2%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,500.00	78,010.00	19,490.00	80.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	44,000.00	66,000.00	40.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,999,200.00	286,000.00	1,713,200.00	14.3%

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	610,000.00	152,260.00	457,740.00	25.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56247800.00	46005150.00	10,242,650.00	81.8%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,331,300.00	45,483,650.00	9,847,650.00	82.2%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	916,500.00	521,500.00	395,000.00	56.9%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18193400.00	17995400.00	198,000.00	98.9%
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,193,400.00	17,995,400.00	198,000.00	98.9%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	11,653,400.00	0.00	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,040,000.00	5,040,000.00	0.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,302,000.00	198,000.00	86.8%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	482,070,300.00	454,547,738.74	27,522,561.26	94.3%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	482,070,300.00	454,547,738.74	27,522,561.26	94.3%
132001	Орон нутгийн төсвөөс	482,070,300.00	454,547,738.74	27,522,561.26	94.3%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	31.00	31.00	0.00	100.0%
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100.0%
620004	Гэрээт ажилтан	10.00	10.00	0.00	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31.00	31.00	0.00	100.0%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14.00	14.00	0.00	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00	0.00	100.0%
650010	Гэрээт ажилтан	10.00	10.00	0.00	100.0%
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	02.00	02.00	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		13,004,365.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		13,004,365.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		13,004,365.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,524,959.00
210402	Тээвэр, шатахуун		2,524,959.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		10479406.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		8,950,906.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,528,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		13004365.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		13,004,365.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		11,614,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		750,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		639,665.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сагил сумын Засаг даргын тамгын газар нь Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ, мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагил сумын Засаг даргын тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 4,748.3 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 632,807.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,328.1 мянган төгрөгийн 80 хувиар буюу 5,062.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,766.4 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	8,693.8	18.4	-8,675.4
Бараа материал	87,698.5	76,084.1	-11,614.4
Үндсэн хөрөнгө	644,292.9	729,349.1	85,056.2
Нийт хөрөнгө	740,685.3	805,451.8	64,766.4
Өр төлбөр	996.3	3,046.6	2,050.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	739,689.0	802,405.1	62,716.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	740,685.3	805,451.8	64,766.4

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 18.4 мянган төгрөг болж 8,675.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны шимтгэлийн авлага 296.6 мянга, хувь хүмүүсээс авах 6,400.0 мянган төгрөгийн авлага бүрэн барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 76,084.1 мянган төгрөг болж 11,614.4 мянган төгрөгөөр буурчээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст мал амьтанд материал нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр зөгийн аж ахуйтай болсонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 729,349.1 мянган төгрөг болж 85,056.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд шинээр нэмэгдсэн хөрөнгө байна. Тайлант онд 71,471.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталжээ. Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй хүлээн авсан болон шилжиж ирсэн 170,605.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,046.6 мянган төгрөг болж 2,050.3 мянган төгрөгөөр өссөн нь халаалт болон газрын төлбөрийн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 802,405.1 мянган төгрөг болж 62,716.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 63,371.7 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь дээд шатны төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 40,666.8 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга 66.6 мянган төгрөгөөр хийгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 427,913.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 427,913.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 9,839.0 мянган төгрөгөөр бууруулан 418,074.0 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийгдэж 63,996.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 482,070.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 482,070.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 482,070.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 486,670.3 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 454,547.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үндсэн данснаас 32,122.6 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 454,547.7 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 11,970.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 750.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,089.6 мянга, нийт 16,809.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 2,524.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 10,479.4 мянга, нийт 13,004.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 3,804.3 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сагил сумын Засаг даргын тамгын газрын авлагын эхний үлдэгдэлд хувь хүмүүсээс авах 6,400.0 мянган төгрөгийн авлага нь тайлант онд шүүхийн шийдвэрийн дагуу барагдсан боловч аудитын хугацаанд иргэний гомдол ирсэн тул Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Сагил сумын Засаг даргын тамгын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахгаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 143, хугацаа хоцроож мэдээлсэн 7 мэдээлэл байна. Мэдээлэх хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 496.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосонд Сагил сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2/75 дугаар албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.АМАРМЭНД/

2022 оны 02 сарын 25-ны өдөр